

Сэдэв: Хүүрнэмж эхийн бүтэц, дараалал, учир шалтгааны уялдаа

Дараах эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Уучлах гэдэг ухааных

Долоо хоногийн эхний өдөр дунд сургуулийн нэгэн багш сурагчдаасаа “Амьдралын ...” гэсэн тодотголтой нэгэн туршилтад орохыг хүссэн байна. Нэр нь их сонирхолтой байсан тул хүүхдүүд дуртай нь аргагүй зөвшөөрчээ.

Багш нь хүүхэд бүрийг 5 килограмм төмс, нэг ширхэг гялгар уут авчрах даалгавар өгсөнд тэд ихэд гайхсан ч маргааш нь бүгд авчирчээ. Багш ангидаа оронгуут асуусан харцаар өөдөөс нь ширтэх шавь нартаа хандан, “Хүүхдүүд ээ! Та нар өнөөдрийг хүртэл үзэн ядаж байсан, эсвэл дургүй хүмүүсийнхээ нэрийг нэг нэг төмсөн дээр бичээд, тор луугаа хийгээд байгаарай.” гэв. Хэдэн минутын дараа зарим хүүхдийн торонд ганц нэг төмс орсон байхад, заримынх нь бүр дүүрэн болсон харагдана. Сурагчдыг торондоо төмсөө хийж дууссаны дараа багш “Одоо тортой төмсүүдээ долоо хоногийн турш хаа явсан газартаа авч яв. Автобусанд суухдаа, хичээлдээ ирэхдээ ч авч яв. Унтахдаа ч орныхоо хажууд тавиарай.” гэлээ.

Товлосон долоо хоног нь дуусаж, багшийг ангидаа орж иртэл, хүүхдүүд “Багш аа! Ийм хүнд ачааг үргэлж авч явах хэцүү байна. Зарим төмс нь бүр ялзарч эхэллээ. Би залхаж байна. Бас ядарч байна.” гэх зэргээр гомдоллож эхлэв.

Эцэс сүүлд нь багш инээмсэглэн байж, “Хүнийг уучлахгүй байх нь тэднийг бус өөрийгөө шийтгэж байдаг.” гэдгийг л та нарт ухааруулах гэсэн юм. “Бусдын алдааг уучлахгүй бол бид сэтгэлдээ энэ төмс шиг хүнд ачааг тээж явдаг юм. Бусдыг уучилна гэдэг өөрөө өөртөө хийж байгаа сайн зүйл шүү дээ.” гэж хэлжээ.

“Сургамжит өгүүллэг” ном, 2014

1. Дараах үйл явдлууд эхийн аль хэсэгт хамаарахыг тодорхойлоорой. Цэгийн оронд нөхөж бичнэ үү.

1. Долоо хоногийн эхний өдөр дунд сургуулийн нэгэн багш сурагчдаасаа “Амьдралын ...” ...аргагүй зөвшөөрчээ.

A.

2. Багш нь хүүхэд бүрийг 5 килограмм төмс ... гэх зэргээр гомдоллож эхлэв.

B.

3. Эцэс сүүлд нь багш инээмсэглэн байж ... Бусдыг уучилна гэдэг өөрөө өөртөө хийж байгаа сайн зүйл шүү дээ.” гэж хэлжээ.

C.

2. Эхийн сэдвийг тодорхойлоорой. Зөвийг сонгоорой.


A. Төмсний тухай

B. Багшийн тухай

C. Даалгаврын тухай

D. Ухаарлын тухай

3. Өгүүлэгдэхүүний бүтцийн хэсэг тус бүрийн үйл явдлын гол утгыг түлхүүр үгээр нэрлэн бичээрэй. Цэгийн оронд нөхнө үү.



4. Үйл явдлын дарааллыг тодорхойлоорой. Холбож зурна уу.

Үйл явдал

1. Багш хүсэлт тавив.
2. Даалгаврыг хүүхдүүд биелүүлэв.
3. Багш туршилтаа эхлэв.
4. Хүүхдүүд ёсоор хийв.
5. Шавь нар нь гомдоллов.
6. Багш учрыг ойлгуулав.

Цаг хугацаа \дараалал

- a) Ингэх үед нь
- b) Хэдэн минутын дараа
- c) Долоо хоногийн эхний өдөр
- d) Долоо хоногийн дараа
- e) Багш ангидаа оронгуутаа
- f) Маргааш нь

5. Хүүрнэмж эхийн үйл явдлын дарааллыг илэрхийлсэн хэлний нэгжийг тодорхойлоорой. Хэлний нэгжид тохирох жишээтэй зөв харгалзуулна уу.

Хэлний нэгж

1. Төлөөлөн холбох үг
2. Цагийн утгатай холбоо үгээр
3. Цагийн нэр үгээр
4. Цагийн утгатай өгүүлбэрээр

Цаг хугацаа \дараалал

- a) Ингэх үед нь
- b) Хэдэн минутын дараа
- c) Долоо хоногийн эхний өдөр
- d) Долоо хоногийн дараа
- e) Багш ангидаа оронгуутаа
- f) Маргааш нь